**ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ**

**Байгууллагын нэр:** Харилцаа холбооны зохицуулах хороо
**Тайлант хугацаа:** 2023.01.01-2023.12.31

| № | АГАДУТ | АГАДУТ-ийн дэд анги | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /төгрөгөөр/ | Материаллаг эсэх | Үр өгөөжөөр тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт: Стандартын заалт | Шалгуур үзүүлэлт: Хууль тогтоомжийн заалт | Алдаа, зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ажил гүйлгээний анги | Зардал | ХХЗХороо нь тайлант онд 25 сургалт, семинар, хэлэлцүүлгийг зохион байгуулж 235,658.9 мянган төгрөгийн зардал гаргаж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна. | 235,658,917.35 | Тийм | Үгүй | "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна", 3.1.3-д " ....төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан, 3.1.11-д "хуульд заасны дагуу Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхий сайдаас байгуулсан хороо, комисс, зөвлөл", 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна. | Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал | Албан шаардлага | Тайлбаргүй | Шийдвэрийг хэвээр үлдээв. | Албан шаардлага |
| 2 | Ажил гүйлгээний анги | Зардал | Тайлант онд албан хэрэгцээнд нэр бүхий ААН-ээс 17,274.3 мянган төгрөгийн тавилга, эд хогшил дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, шууд худалдан авсан байна. | 17,274,730.00 | Тийм | Үгүй | "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна", 3.1.3-д " ....төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан, 3.1.11-д "хуульд заасны дагуу Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхий сайдаас байгуулсан хороо, комисс, зөвлөл", 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.2-т "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д заасныар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", ТБОНӨХБАУХАТ хуулиийн 8 дугаар зүйлийн 8.13-д "Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна. | Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал | Албан шаардлага | Тайлбаргүй | Шийдвэрийг хэвээр үлдээв. | Албан шаардлага |
| 3 | Ажил гүйлгээний анги | Дотоод хяналт | Өмнөх аудитаар өгсөн "Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, эрсдэлийг оновчтой тодорхойлон үр дүнтэй аудитыг хийж гүйцэтгэх" зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | - | Үгүй | Үгүй | "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга | МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжээгүй бол" гэж заасаны дагуу. | аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжээгүй бол | Албан шаардлага | Тайлбаргүй | Шийдвэрийг хэвээр үлдээв. | Албан шаардлага |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Дансны үлдэгдэл | Дансны авлага | Тайлант онд төлбөртэй үйлчилгээний 232,025.3 мянган төгрөг, байгууллагаас авах 16,537.2 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 213,400.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. | 461,963,465.98 | Тийм | Үгүй | "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй байна. | Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Зөвлөмж | Тайлбаргүй | Шийдвэрийг хэвээр үлдээв. | Зөвлөмж |
| 5 | Дансны үлдэгдэл | Дансны өр төлбөр | Тайлант онд ажиллагчидтай холбогдсон 30,897.3 мянган төгрөг, хувь хүмүүст өгөх 170.0 мянган төгрөгийн дансны өр төлбөрийн үлдэдэлтэй байна. | 31,067,394.13 | Тийм | Үгүй | "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй байна. | Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Зөвлөмж | Тайлбаргүй | Шийдвэрийг хэвээр үлдээв. | Зөвлөмж |
| 6 | Нийцэл | Шилэн данс | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 372,176.7 мянган төгрөгийн 5 гүйлгээ, зарлагын 523,788.7 мянган төгрөгийн 11 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна. | 895,965,389.13 | Үгүй | Үгүй | "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга | Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй байна. | Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Зөвлөмж | Тайлбаргүй | Шийдвэрийг хэвээр үлдээв. | Зөвлөмж |
| 7 | Нийцэл | Төрийн албаны тухай хууль | ХХЗХорооны даргын 2020 оны А/131 дүгээр "Журам шинэчлэн батлах тухай тушаал" нь Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйл, 3Г-ын 2019 оны 05 дугаар тогтоолтой нийцэхгүй байна. | - | Үгүй | Үгүй | "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга | Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", 51.2-т " ... 51.1.4-т заасан мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар, ...", Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна. | Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал | Албан шаардлага | Тайлбаргүй | Шийдвэрийг хэвээр үлдээв. | Албан шаардлага |
| | | | Нийт дүн | 1,641,929,896.59 | | | | | | | | | |

**Бэлтгэсэн:** Ахлах аудитор — С.Бат-Эрдэнэ — Огноо:

Аудитор — П.Ариунзаяа — Огноо:

**Хянасан:** Аудитын менежер — Ч.Болд — Огноо:

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор — Н.Наранчимэг — Огноо:

**Танилцсан:**

Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга — Г.Чинзориг — Огноо:

Санхүүгийн хэлтсийн дарга — Н.Халиунаа — Огноо: